



СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№197 /407/

2022.11.02

Цаг үе, үйл явдал

БАХАРХАМ ТҮҮХ БАЙГУУЛСАН ГАВЬЯАТАЙ ҮЛГЭР ЖИШЭЭГИЙНХЭН



С.Саруул-Од болон ҮЖҮНХ-ийн бие бүрэлдэхүүн оролцсон юм.

Хичээлийн шинэ жилийн анхны хичээлийг зочин багш дэслэгч С.Саруул-Од "Жазз хөгжмийн үүсэл хөгжил, төрөл мэргэжлийн онцлог" сэдвийн хүрээнд лекц, семинар хэлбэрээр орж хэлэлцүүлэг өрнүүлэн харилцан туршлага солилцлоо.

Монгол Улсын Төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн ажиллагаа, гадаад, дотоодын дээд хэмжээний зочид төлөөлөгчдийг хүндэтгэн угтах, Зэвсэгт

хүчнийг сурталчлах үүргээ нэр төртэй биелүүлж ирсэн эл хамт олон 2022-2023 оны хичээлийн жилд офицер, ахлагч нарынхаа цэргийн хэргийн мэдлэг, дадлагыг нэмэгдүүлэх, байлдааны тасаг, бүлгээр үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх, улмаар илүү мэргэжлийн түвшинд хүрэх, үлгэрлэн манлайлагчид байх зорилтыг дэвшүүлжээ. Түүнчлэн алба хаагчдынхаа эрүүл мэнд, хувь хүний хөгжил, нийгмийн хамгааллын асуудлуудыг ч орхигдуулахгүй гэдгийг удирдлагууд нь онцолж байв.

Х.УНДАРМАА

Байлдааны гавьяаны болон Нээлтийн үйл ажиллагаанд Алтангас одонт Зэвсэгт хүчний 142 дугаар анги буюу Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн нээлт боллоо.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|--------|
| ☀️ 0 | ☁️ -14 |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 36 | ☁️ 23 |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ | ЗАРАХ |
|--------|-------|-------|
| USD 🇺🇸 | 3,412 | 3,418 |
| EUR 🇪🇺 | 3,395 | 3,430 |
| CNY 🇨🇳 | 464 | 469 |
| RUB 🇷🇺 | 52.20 | 52.26 |
| JPY 🇯🇵 | 23 | 23.40 |
| KRW 🇰🇷 | 2.40 | 2.44 |

ЗУРХАЙ



2022.11.02 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 9

НАМРЫН АДАГ ЦАГААН НОХОЙ САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ХОНЬ ӨДӨР

ШИЛДЭГ ТЕХНОЛОГИОР БАТАЛГААТАЙ ОРЧНЫГ БИЙ БОЛГОНО



Кибер орон зайн аливаа сахуулагчид болох ЗХЖШ-ын халдлага, довтолгооноос хамгаалан Кибер аюулгүй байдлын цэргийн тэмцэгч, аюулгүй байдлыг командлалын 2022-2023 оны

хичээлийн шинэ жилийн нээлт болж, жигдрэлтийн сургуулийн төлөвлөгөөгөө баталлаа.

Хичээлийн шинэ жилийн нээлтийг хийж КАБЦК-ын Төлөвлөлтийн хэлтсийн хамтын ажиллагааны офицер дэд хурандаа Д.Мөнхбат "Харилцааны ур чадвар" сэдвээр илтгэл тавьсан төдийгүй "Урьд нь бид манлайллыг зөвхөн удирдлагын албан тушаалтан эсвэл ямар нэг байгууллагад хамаатуулан ойлгодог байлаа. Тэгвэл манлайллын тухай энэ хэвшмэл ойлголт нь өдгөө өөрийн багахан хүрээлээс эхлэн амьдарч буй нийгэм, цаашлаад байгаль эх дэлхийн асуудлуудад гарц шийдэл олохоор зорьж, түүнийхээ төлөө бодит алхам хийж буй хүн бүрийн тухай ойлголт болон хувьсаж байна.

Тиймээс алба хаагч бүр үлгэр жишээ байж, манлайллыг жанжин шугамаа болгон, түүний үр шим, давуу талыг бодит ажил хэрэг болгох нь чухал" хэмээн онцолж байлаа.

Нээлтийн үйл ажиллагаанд Кибер аюулгүй байдлын цэргийн командлалын нийт бие бүрэлдэхүүн оролцож, тулгамдаж буй асуудал болоод ололт амжилтаа хэлэлцэн дүгнэж, өмнөө тавьсан зорилго, цаашид Монгол Улсын аюулгүй байдлын урт болон дунд хугацааны зорилтод тулгуурласан төсөл, хөтөлбөрүүдээ үе шаттайгаар хэрэгжүүлж, чадварлаг хүний нөөц, шилдэг техник технологи, баталгаатай орчныг бий болгохоор зорьжээ.

Х.УНДАРМАА

МАНЛАЙЛАГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН КЛУБТ ТАВТАЙ МОРИЛ

ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болорын санаачилгаар Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд алба хааж байгаа мөрдөстэй болон энгийн ажилтан албан хаагч эмэгтэйчүүдийн манлайллын ур чадварыг дээшлүүлэх, эерэг хандлага, харилцааны гоо зүйг түгээх, багаар ажиллах чадвар болон нийгмийн оролцоог идэвхжүүлэх зорилготой "Эмэгтэйчүүдийн клуб"-ийг байгууллаа.

Тус клубийн нээлтийн арга хэмжээг өчигдөр Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ, аж ахуйн хэлтсийн эмэгтэйчүүдийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан юм.

Тус клубийн үйл ажиллагааг нээж бригадын генерал Г.Болор хэлсэн үгэндээ "Эмэгтэйчүүдийн манлайлал өөртөө итгэх итгэлээс



эхэлдэг. Хамгийн түрүүнд тухайн эмэгтэй хүн өөрийгөө манлайлагч болно гэдэгт итгэлтэй байх хэрэгтэй. Нэг үгээр хэлэхэд өөртөө итгэх итгэл л тулах цэг юм гэж хардаг. Ихэнх

эмэгтэйчүүд би чадахгүй, надаас хол зүйл гэж өөрийгөө хайрцаглах тал түгээмэл анзаарагддаг. Энэ үзлээ л өөрөөсөө холдуулж чадвал манлайлагч болох эхний алхмаа хийж чадлаа гэж

хараарай. Манлайллыг холоос хайх хэрэггүй. Гэр бүлээсээ, гэрийн ажлаа хувааж хийхээс эхэл. Цаг наргүй үргэлжлэх ахуйн чанартай их ажлыг хуваалцаж хөнгөвчлөөд ирэхээр өөртөө зарцуулах цаг завтай болно. Агуу бүхэн энгийнээс эхэлдэг гэдэг шүү дээ" хэмээн тодотгов.

Мөн энэ үеэр клубийн үйл ажиллагааг цаашид хэрхэн өрнүүлэх, ямар ажлуудыг хэрэгжүүлэх талаар клубийн гишүүдийн санал сэтгэгдлийг сонссон бөгөөд тэд сар бүрийн нэгний өдөр уламжлал болгон уулзалтыг зохион байгуулах, хувь хүний хөгжлийн сургагч багш нарын лекц сонсох, хөдөлгөөнт бүжиг, иог зэрэгт клубээрээ нэгдэн оролцох зэрэг санал санаачилгыг дэвшүүллээ.

Х.УНДАРМАА

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 635,979,083

Эдгэрсэн


Нийт: 615,395,619

Нас барсан

Нийт: 6,595,657

Цаг үе, үйл явдал

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ДЭМЖИЖ АЖИЛЛАНА



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага / ЖАЙКА-ын Ерөнхийлөгч А.Танака-г хүлээн авч уулзав.

Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог бэхжүүлж, тогтвортой хөгжлийг хангахад Япон Улсын дэмжлэг, хөнгөлөлттэй

зээл, тусламж онцгой үүрэг гүйцэтгэж ирснийг Ерөнхийлөгч тэмдэглэв.

Ялангуяа боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй зэрэг салбарт тууштай дэмжлэг үзүүлж ирснийг Монголын төр, засаг, ард түмэн өндрөөр үнэлдгийг дурдаж, ЖАЙКА-ын тусламж цаг үеэ олсон, иргэдэд хүртээмжтэй, сэтгэл шингэсэн байдгийг онцлов.

Цаашид уул уурхай, газрын ховор элемент, хөдөө аж ахуй, хүнс, аялал жуулчлал зэрэг салбарт хамтран ажиллах өргөн боломж байгааг хэлэв.

А.Танака сүүлийн жилүүдэд Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг товч танилцуулж, “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл

монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд нягт хамтран ажиллахаа илэрхийлэв.

Ерөнхийлөгч А.Танака-гийн энэ удаагийн айлчлал хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жил, ЖАЙКА-ын Монгол дахь Төлөөлөгчийн газар байгуулагдсаны 25 жил, ЖАЙКА-ын далайн чанад дахь сайн дурын

гишүүд Монголд томилогдон ажиллаж эхэлсний 30 жилийн ойн хүрээнд болж байна.

А.Танака нь ЖАЙКА-ын Ерөнхийлөгчөөр хоёр дахь удаагаа томилогдон ажиллаж байгаа бөгөөд 2014 онд Монгол Улсад айлчилж байсан юм.

PRESIDENT.MN

ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТИЙГ ХЭЭРИЙН БАЙРЛАЛД ЗОХИОН ЯВУУЛЛАА



Хошууч генерал Р.Гаваагийн нэрэмжит, Цэргийн гавьяаны улаан тугийн болон Алтан гадас одонт Зэвсэгт хүчний 013 дугаар анги энэ сарын 1-ний өдөр дадлагын дохиогоор ажиллаж, шинэ сургуулийн жилийн нээлтийн арга хэмжээ мөн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу ангийн бие бүрэлдэхүүнтэй явуулах тактик, тусгай бэлтгэлийн 30 км-ийн явган маршийг хээрийн байрлалд хослуулан зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагааг

нээж ангийн захирагч хурандаа Ч.Эрдэнэболд нийт бие бүрэлдэхүүнд хандан “Энэ жил их онцлогтой жил. Хугацаат цэргийн албанаас бэлтгэлээр халагдсан дайчид маань ахлагчийн албанд шилжиж бид бүхэнтэй мөр зэрэгцэн алба хаан үүрэг гүйцэтгэж байна.

Мөн цар тахлын үеийн хорио цээр бүрэн цуцлагдлаа. Тиймээс бид энэ тайван цаг ирж байгаатай холбогдуулан үндсэн үүргээ эх орныхоо өмнө илүү сайн биелүүлэх хэрэгтэй” хэмээн тодотгосон юм.

Тус арга хэмжээний дараа цэргийн анхан шатны сургалт бэлтгэлд хамрагдаж байгаа шинэ дайчдын нэг өдрийн хичээл сургуулийг хөтөлбөрийн дагуу хээрийн байрлалд зохион явуулсан бол байнгын бие бүрэлдэхүүн цааш хөдөлгөөн үйлдэн тактик, тусгай бэлтгэлийн 30 км-ийн явган маршийг хордсон газар орныг туулах, тактикийн ажиллагаа, эмнэлгийн татан гаргалт, отолтын эсрэг ажиллагаа гэсэн дөрвөн цэгээр амжилттай зохион байгуулж явууллаа. Хошууч З.АНХБАЯР

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ ХАЙГУУЛ УСТГАЛЫН БҮЛЭГ АЖИЛЛАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Тус ангийн томилгоот бүрэлдэхүүн Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт Зөвлөлт холбоот Улсын цэргийн анги, нэгтгэлүүд байрлаж байсан суурин газар, хээрийн сургуулилт хийж байсан талбайд тэсэрч дэлбэрээгүй үлдсэн сум галт хэрэглэлийг илрүүлж, устгах ажлыг зохион байгуулж байна. Тэсэрч дэлбэрээгүй

үлдсэн сум, галт хэрэгсэлд иргэд санамсар болгоомжгүй байдлаар өртөн бэртэж гэмтэх аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү хайгуулыг зохион байгуулж байгаа бөгөөд ангийн захирагч хурандаа Н.Цэцэнхүү, захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Л.Амарсанаа нар ахлан гүйцэтгэж байна.

ШИНЭ СУРГУУЛИЙН ЖИЛИЙН БОДЛОГО, ЗОРИЛТЫГ ТАНИЛЦУУЛАВ



Зэвсэгт хүчний 310 дугаар анги

Шинэ сургуулийн жилийн нээлтийг тохиолдуулан ангийн удирдлага, штабын офицерууд, тасаг, албадын дарга нар болон даргалах албан тушаалын ахлагч нартай заах арга зүйн цугларалтыг 10 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулав. Энэхүү цугларалтаар шинэ сургуулийн жилийн зорилго, зорилт болон хичээлийн хөтөлбөрүүдийг бие бүрэлдэхүүнд танилцуулахын зэрэгцээ, ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн багш Б.Дарханцэцэг “Багаар ажиллах чадвар”, Монголын гэр бүл судлаачдын мэргэжлийн

холбооны тэргүүн Н.Баясгалан “Гэр бүл төлөвлөлт”, МУБИС-ийн Сэтгэл зүйн төвийн багш Ж.Баярхүү “Харилцаа ба хандлага” сэдвээр тус тус лекц уншиж, харилцан ярилцлагыг өрнүүлээ. Мөн Заах арга зүйн цугларалтын хүрээнд тус ангийн бие бүрэлдэхүүн “БЭСТ ШҮЕС” болон “Хүн од” компани, Техник, технологийн дээд сургуулийн сургалтын үйл ажиллагаатай танилцаж, сургалт, дадлага явуулж буй танхимуудыг үзэж сонирхсон бөгөөд энэ үеэр доктор М.Мөнхцэцэг “Сэтгэл хэмээх ойлголтыг буддын философид авч үзэх нь” сэдвээр яриа таниулга хийсэн юм.

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №15

7 ЭГШГИЙГ УНШИХ, БИЧИХ

Монгол хэл 7 богино эгшигтэй. Эдгээр нь А, Э, И, О, У, Ө, Ү гэсэн дараалалтай. Долоон эгшгийн зөвхөн үгийн эхэнд орох хэлбэрийг авч үзье.

Үгийн эхэнд бүх эгшиг ТИТЭМ зурлагаар эхэлдэг. Тиймээс эхлээд хөндлөн тийш 7 титэм бичье.

Дармалаар:

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| а | э | и | о | у | ө | ү |
| → | → | → | → | → | → | → |

Бичмэлээр:

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| ? | ? | ? | ? | ? | ? | ? |
|---|---|---|---|---|---|---|

Одоо эгшиг тус бүрийн титмийн доор нэмэгдэх зурлагыг бичиж үзүүлье:

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| → | → | → | → | → | → | → |
| + | + | + | + | + | + | + |
| 1 | 0 | 1 | 4 | 4 | 4 | 4 |
| | | | | | + | + |
| ↖ | → | ↗ | ↖ | ↖ | 1 | 1 |
| | | | | | | |